**Эрүүл Мэндийн Газар Хяналт Шинжилгээ Үнэлгээ**
**Мэдээлэлийн Хэлтэсээс бэлтгэн гаргав**

Мэдээ хянасан
ХШҮМ*Х-ийн дарга Д.Наранмичид*

Мэдээ нэгтгэсэн
Мэргэжилтэн *Т.Ууганжаргал*
Утас : 70562096
*Вэб сайт:mohs.khe.gov.mn*

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх
Хэрэгжүүлэгч агентлаг
Эрүүл Мэндийн Газар

# ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ
# 2023 ОНЫ 5 САР

**Чингис хот**

**Эх, хүүхдийн эрүүл мэнд**
/2023 оны 5 сарын байдлаар/

***Төрөлт***

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 5 сарын байдлаар нийт 540 эх төрсөн ба өнгөрсөн оны мөн үеэс 22 төрөлтөөр буюу 4,1 хувиар өссөн байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт 80.3% /434/ нь сумдаас ирж төрсөн байна.
Кесар хагалгаагаар төрсөн /142/ 26.3 хувийг эзэлж байна

***Хүүхдийн эрүүл мэнд***

2023 оны 5 сард Аймгийн хэмжээнд 545 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 22 хүүхдээр буюу 4,0 хувиар өссөн байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 264 буюу 48,4 хувь нь эрэгтэй, 281 буюу 51.6 хувь нь эмэгтэй байна. Амьд төрсөн хүүхдийн 3.1/17/ хувь нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төржээ. Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 98,8 байна.

***Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл***

Аймгийн хэмжээнд 2023 оны 5 сард нялхасын эндэгдэл 6 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөд 11.0 байна. Улсын дундаж 13,0
5 хүртэлх насны эндэгдэл 7 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөд 12,8 байгаа нь өмнөх оны түвшинд байна. Улсын дундаж 15.1 промил байна.

***Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан***

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл: Нярайн амьсгалын гачаал-2, нярайн тархины хямрал-1, нярайн хүчилтөрөгчийн дутмагшил, хатгалгаа-1, тархины цус харвалт-1, осол гэмтэл-1 тус тус бүртгэгдсэн байна.

***Жирэмсний хяналт***

Жирэмсэний хяналтанд шинээр 575 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 92,7 хувь нь эхний 3 сартайд, 6,6 хувь нь 4-6 сартайд, 7 дээш сартайд 0,7 хувь нь хяналтанд орсон байна. Хяналтанд орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 96,9 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсан ба цус багадалттай жирэмсэн 3 бүртгэгдсэн байна.
Шинээр хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээнд 437 буюу 76,0 хувь нь эерэг-6, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 436 буюу 75,8 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 566 буюу 98,4 хувь, эерэг-6, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 566 буюу 98,4 хувь тус тус хамрагдсан байна.

## ***Нас баралтын үзүүлэлтүүд***

2023 оны эхний 5 сарын байдлаар нийт нас баралтын 138 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 15 тохиолдлоор буурсан байна. 94 буюу 68,1 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Нас баралтын түвшин 1000 хүн амд 1,7 байна.

Нийт нас баралтын /50/36,2 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс /15/30,0 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна.. 8-24 цагийн дотор 5 тохиолдол бүртгэгдсэн байна.

Хорт хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын /38/ 27,5 хувийг эзэлж байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 29 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 21,0 хувийг эзэлж байна. Амиа хорлосон-5, бусдад хорлогдсон 1 тохиолдол, зам тээврийн осол-10, бусад осол-13 тус тус бүртгэгдсэн байна. 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 3,6 байна.

2023 оны эхний 5 сарын байдлаар артери гипертензийн эрт илрүүлэг үзлэгт нийт 11327/22,3%/ хүн хамрагдаж 59,7 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр онош батлагдсан 173 байна. Чихрийн шижин эрт илрүүлэг үзлэгт 35 дээш насанд 10099/32,4%/ хамрагдаж онош батлагдсан 33 тохиолдол байна.

Хөхний эрт илрүүлэг үзлэгт 3419/17,3%/ хүн хамрагдаж, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт 695/15,5%/ хүн хамрагдсан байна.

## ***Амбулатори ,стационарын тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд***

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 5 сарын байдлаар эмнэлэгт 9035 хүн хэвтэн эмчлүүлж нийт 68125 ор хоног ашигласан бөгөөд дундаж ор хоног 7,0 байна.

Амбулаторит 2023 оны эхний 5 сарын байдлаар 147168 үзлэг хийгдсэний 16,8 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 65.9 хувийг өвчний учир амбулаторит, 10,3 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, үлдэх 7,0 хувийг гэрийн идэвхитэй болон дуудлагын үзлэг эзэлж байна.

Халдварт бус өвчлөл 50490 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеийнхээс 13110 өвчлөлөөр өссөн үзүүлэлттэй байна.

2023 оны 5 сарын байдлаар Осол гэмтлийн өвчлөлийн нийт 631 тохиолдол бүртгэгдсэнээс /420/66,6 эрэгтэй, /211/33,4 эмэгтэй байна. Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаанд: бүх төрлийн уналт /183/29.0%, зам тээврийн осол /122/19,3%, амьгүй механик хүчин өртөх /119/18.9%, хүчирхийлэл /89/ 14.1% түлэгдэлт /49/ 7,8%, тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны 5 сарын байдлаар 8710 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч гүйцэтгэснээс 16,5% нь алсын дуудлага эзэлж байгаа нь өмнөх оноос 3,0 хувиар буурсан байна. Осол гэмтлийн 183 дуудлага бүртгэгдсэн байна.

## ХАЛДВАРТ ӨВЧИН

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 5 сарын байдлаар 252 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 31.6 ногдож байна. /Улсын дундаж 37.1/
Улс аймгийн дундажаас доогуур үзүүлэлттэй байна.

***10000 хүн амд ногдох халдварт өвчин***
*2023 оны эхний 5 сарын байдлаар*

## Халдварт өвчин бүтэц

Нийт халдварт дотор Салхинцэцэг /91/ 36,1 хувь, БЗДХ /57/ 22.6 хувь, сүрьеэ /29/ 11,5 хувь, ковид-/18/ 7.1 хувь цусан суулга /4/1,6 хувь, тус тус бүртгэгдсэн байна.

БЗДХ-ын 48 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 6,0 байна.
БЗДХ-ын дотор тэмбүү /17/, гонококкт халдвар /20/, трихомониз /20/, тохиолдол бүртгэгдэж урьд оноос 21 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.